



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 5/19

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 2.1.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Ажлын хувцас, хэрэгсэл ашиглалтын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
- Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Θмч хамгаалах байнгын зөвлөл /С.Доржсүрэн/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ



1150500037

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2019 оны 02-р сарын 22-ны өдрийн
...../19.. дүгээр тушаалын хавсралт

АЖЛЫН ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ АШИГЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмын зорилго нь Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдад ажлын хувцас, хэрэгслийг заавар болон зориулалтын дагуу тогтмол, зөв хэрэглэж хэвшүүлэх, ажлын хувцас хэрэгсэл олгох, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих замаар ашиглалтыг сайжруулах, хэрэглэх норм хугацааг тогтооход оршино.

1.2 Журмын хэрэгжилтийг газрын нийт ажилтан, албан хаагчид дагаж мөрдөх ба хэрэгжилтэд салбар нэгжийн удирдлага хяналт тавьж ажиллана.

1.3 Ажлын хувцас, хэрэгслийн ашиглалтын норм ба хугацааг А хавсралтаар, Цэвэрлэгээ, үйлчилгээний ажилтны ажлын хэрэгсэл, ашиглалтын хугацааг Б хавсралтаар, Инженер, техникийн ажилтны ажлын хэрэгсэл, ашиглалтын хугацааг В хавсралтаар тус тус тогтоов.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1 Энэхүү журамд хэрэглэгдэж буй дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
Үүнд:

2.1.1 "Ажлын байр" – Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байр;

2.1.2 Ажлын хувцас, хэрэгсэл: Ажилтан, албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэхэд нь зориулж олгосон ажлын хувцас, хөдөлмөр хамгааллын болон цэвэрлэгээ үйлчилгээний хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, ажлын багаж, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл зэргийг;

2.1.3 Хамгаалах хэрэгсэл: Ажилтан, албан хаагчдыг цахилгааны үйлчлэл, өндөрөөс унах, галд өртөх, дулаан ба механик үйлчлэлд нэрвэгдэхээс болон гэмтэхээс хамгаалахад зориулсан, аюулгүй байдлыг бүрэн хангаж чадах тусгай материалыар хийсэн хөдөлмөрийн багаж хэрэгслийг;

2.1.4 Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл: Ажлын байрны хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах зориулалт бүхий стандартад нийцсэн дараах хэрэгслүүдийг хэлнэ:

- хамгаалалтын болон гэрэл ойлгогч бүхий хувцас;
- толгойн хамгаалах хэрэгсэл;
- нүд хамгаалах хэрэгсэл;
- хөл хамгаалах хэрэгсэл;
- гар хамгаалах хэрэгсэл;
- сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл;
- амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл;
- уналтаас хамгаалах аюулгүйн бус зэрэг багтана.

2.1.5 Ажлын хувцасны иж бүрдэл нь доорх хэсгээс бүрдэнэ:

- Өвөл: Куртик, өмд
- Зун : Цамц, өмд

2.1.6 Осол: Үйлдвэрлэл түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцож байх явцдаа бие эрхтэн нь гэмтэх, эрүүл мэнд нь хохирох үйл явц;

2.1.7 Эрсдэл: Осол учруулах магадлалтай тохиолдлуудын нийлбэр буюу тухайн ослын зэрэглэл.

Гурав. Ажлын хувцас, хэрэгслийн өрөнхий шаардлага

- 3.1 Ажилтан, албан хаагчдын ажлын хувцас, хэрэгсэл нь батлагдсан өнгө загвар, иж бүрдэл бүхий, зохих стандартын шаардлага хангасан байна.
- 3.2 Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл нь тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд зохицсон эсэхийг ажилтан болон шууд удирдлага доорх шаардлагуудын дагуу магадална:
- 3.2.1 ажлын тусгай хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь ажил үүргээ гүйцэтгэх үед саад болохооргүй байх;
- 3.2.2 ажилтныг шаардагдах төвшинд хамгаалахаас гадна, хүний биед тохиromжтой байх;
- 3.2.3 ажлын хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа үүсгэхгүй, ширүүн хурц ирмэггүй байх;
- 3.2.4 хувцасны загвар нь хөдөлмөрийн нөхцөл биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц эсвэл хэмжээний өргөн сонголттой байх;
- 3.2.5 хувцасны хамгаалалтын төвшин өндөр, бөх бат материалыар хийгдсэн, биед хөнгөн, эдийн засгийн хувьд үр ашигтай байх;
- 3.2.6 ажлын хувцас нь боломжит хэмжээгээр гаднаас ус уур нэвтрүүлэхгүй, биед нөлөөлөх гадны хүчин зүйлийг багасгах нөлөөтэй байх;
- 3.2.7 хамгаалах хэрэгслүүд нь MNS 4931:2000, 5388:2004, 5389:2004, 5620:2006, 5621:2006, 5622:2006, 5623:2006, 5624:2006 стандартуудыг хангасан байх;
- 3.2.8 хамгаалах хэрэгсэл бүр баталсан норматив техникийн баримт бичигтэй, биеийг гадны нөлөөллөөс бүрэн хамгаалах чадвартай, гоо зүйн болон эргономикийн шаардлага хангасан байх;
- 3.2.9 тусгай хамгаалах хэрэгсэл нь ашиглалт, эрүүл ахуй, физиологи, хамгаалалтын үнэлгээг үнэлсэн үзүүлэлт, ашиглалтын заавартай байх.
- 3.3 Ажилтан өөрийн хариуцсан ажлын хувцас, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах үүрэгтэй.
- 3.4 Ээлжийн амралт, хуваарьт амралт, ажлын бус цагаар ажлын хувцас, хэрэгслийг хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

Дөрөв. Ажлын хувцас, хэрэгсэл олгох

- 4.1 Ажилтан, албан хаагчдад ажлын хувцас, хэрэгслийг нягтлан бодогчийн зөвшөөрлөөр аж ахуй хариуцсан нярав хуваарийн дагуу олгож, энэ тухай бүртгэл хөтөлж баталгаажуулна.
- 4.2 Шинээр ажилд орсон болон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн эдэлгээний хугацаа дууссан ажилтнуудад батлагдсан нормын дагуу хувцас шинээр олгоно.
- 4.3 Ажлын хувцас, хэрэгслийг ажлын нөхцөл болон элэгдлээр нь тооцон нэмж олгоходо тухай ажилтнаар “Шаардах хуудас” бичүүлж, нягтлан бодогчийн зөвшөөрлийг авсан байна.
- 4.4 Ажлын хувцас, хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан, дахин ашиглах боломжгүй болсон, аюулгүйн шаардлага хангахгүй болох зэрэг шалтгааны улмаас солих шаардлага гарсан бол шууд удирдлагадаа хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

Тав. Ажлын хувцас, хэрэгслийн ашиглалт, хэрэглээ

- 5.1 Ажлын хувцас хэрэгслийг зөвхөн ажил үүргээ гүйцэтгэх үедээ хэрэглэж, нормын хугацаанд бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.
- 5.2 Эзэмшигч нь өөрийн буруугаас ажлын хувцас хэрэгслийг ашиглалтын хугацаанаас өмнө чанарыг мутгасан, хаяж үрэгдүүлсэн, гэмтээсэн зэрэгээр дахин ашиглах боломжгүй болгосон тохиолдолд эд хөрөнгийн бүртгэл хяналтын картад тусгасан дунгээс элэгдэл

хорогдлыг тооцсон дүнгээр байгууллагад учруулсан хохирлыг барагдуулна.

5.3 Ажилтан, албан хаагч нь ажлын хувцас хэрэгслийн үнийг бүрэн төлсөн үед дахин олгож болно.

5.4 Эзэмшигч ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ зайлшгүй шалтгааны улмаас ажлын хувцас хэрэгслийг /аваар осол гэх мэт/ дахин ашиглах боломжгүй болгосон тохиолдолд уг асуудлыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу шийдвэрлэнэ.

5.5 Эзэмшигч тодорхой шалтгааны улмаас ажлаас чөлөөлөгдөх үед ажлын хувцас хэрэгслийг байгууллагад буцаан өгнө.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1 Журмын хэрэгжилтэд салбар нэгжийн удирдлага болон өмч хамгаалах байнгын зөвлөл хяналт тавьж ажиллах бөгөөд журам зөрчсөн ажилтан, албан хаагч Хөдөлмөрийн тухай хууль, газрын хөдөлмөрийн дотоод журам, Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ болон энэхүү журамд заасан хариуцлагыг хүлээнэ.

6.2 Ажилтан санаатай болон болгоомжгүй үйлдлийн улмаас ажлын хувцас хэрэгслийг дахин хэрэглэх боломжгүй болгосон тохиолдолд журмын 5 дугаар зүйлд зааснаар хариуцлага ногдуулж, учирсан хохирлыг барагдуулна.

6.3 Шууд удирдлага нь ажилтны ажлын хувцас хэрэгслийн ашиглалтад хяналт тавих ба ажлын хувцас хэрэгслийг ажлын байрнаас өөр газарт, хувийн зорилгоор удаа дараа хэргэлсэн тохиолдолд захиргааны арга хэмжээ авах санал гаргах эрхтэй.

А.ХАВСРАЛТ

Ажилтан, албан тушаалын нэр

№	Албан тушаалын нэр	Ажлын хувцас хэрэгсэл	Тоо хэмжээ	Эдэлгээний хугацаа
1	2	3	4	5
1	Эмч	Эмчийн өмд цамц, цагаан халат	1 ширхэг	2 жил
2	Сувилагч	Сувилагчийн өмд цамц, цагаан халат	1 ширхэг	2 жил
3	Хурлын заалны зохион байгуулагч	Эрэгтэй: пиджак, жилет, өмдний хослол	1 ширхэг	2 жил
		Эмэгтэй: пиджак, жилет, юбканы хослол		
4	Угтах үйлчилгээний ажилтан	Эрэгтэй: пиджак, жилет, өмдний хослол	1 ширхэг	2 жил
		Эмэгтэй: пиджак, жилет, юбканы хослол		
5	Тогооч	Өмд, цамцны хослол	1 ширхэг	2 жил
		Хормогч	1 ширхэг	1 жил
		Малгай, бээлий	Нэг удаагийн	
6	Бэлтгэгч	Өмд, цамцны хослол	1 ширхэг	2 жил
		Хормогч	1 ширхэг	1 жил
		Малгай, бээлий	Нэг удаагийн	
7	Зөөгч	Эрэгтэй: жилет, өмдний хослол	1 ширхэг	2 жил
		Эмэгтэй: пиджак, жилет, юбканы хослол	1 ширхэг	2 жил
		Эрэгтэй: Үндэсний загвар бүхий жилет, цамц	1 ширхэг	2 жил
		Эмэгтэй: Үндэсний загвар бүхий дээл	1 ширхэг	2 жил
		Бээлий	1 ширхэг	1 жил
8	Угаагч	Өмд, цамцны хослол	1 ширхэг	2 жил
		Хормогч	1 ширхэг	1 жил
		Малгай, бээлий	Нэг удаагийн	
9	Мужаан	Өмд, цамц, жилетний хослол	1 ширхэг	1 жил
		Бээлий	1 ширхэг	6 сар
10	Цахилгаанчин	Өмд, цамц, жилетний хослол	1 ширхэг	1 жил
		Бээлий	1 ширхэг	6 сар
11	Слесарь	Өмд, цамц, жилетний хослол	1 ширхэг	1 жил
		Бээлий	1 ширхэг	6 сар
12	Оператор	Өмд, цамц, жилетний хослол	1 ширхэг	2 жил
13	Лифтчин	Эрэгтэй: жилет, өмдний хослол	1 ширхэг	2 жил
		Эмэгтэй: пиджак, жилет, юбканы хослол		
14	Ажлын өрөөний үйлчлэгч	Ажлын өмд, цамцны хослол	1 ширхэг	1 жил
		Хүйтний улиралд ажлын зузаан цамц	1 ширхэг	2 жил
15	Ариун цэврийн өрөөний үйлчлэгч	Ажлын өмд, цамцны хослол	1 ширхэг	1 жил
		Хүйтний улиралд ажлын зузаан цамц	1 ширхэг	2 жил
		Амны хаалт	1 ширхэг	Улирал тутамд

16	Гадна үйлчлэгч	талбайн	Ажлын өмд, цамцны хослол	1 ширхэг	1 жил
			Хүйтний улиралд зузаан дотортой өмд куртикны хослол	1 ширхэг	2 жил
			Хүйтний улиралд хөвөнтэй бээлий	1 ширхэг	6 сар
17	Жижүүр		Жилет, өмдний хослол	1 ширхэг	1 жил

Б. ХАВСРАЛТ

Үйлчилгээний ажиллагсдын ажлын хэрэгсэл,
бараа материалын норм ба хугацаа

№	Ажлын хэрэгслийн нэр	Ашиглалтын хугацаа	Тоо хэмжээ
1	2	3	4
Үйлчилгээний ажилтан			
1	Тоос сорогч машин	Элэгдэл тооцох хугацаагаар	1 ширхэг
2	Хивс болон чулуун шал угаач машин	Элэгдэл тооцох хугацаагаар	1 ширхэг
3	Өндрийн цэвэрлэгээний шат	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Хамгаалалтын бус	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Цонх угаах иштэй татуурга	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Илгэн алчуур /шил, толь, компьютер арчих/	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 улирлаас дээш хугацаагаар	1 ширхэг
7	Шал угаах алчуур	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	2 метр
8	6 төрөл тоосны алчуур эсвэл зориулалтын мөн тооны өнгийн алчуур	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 2 сараас дээш хугацаагаар	2 метр
9	Резинэн бээлий	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	2 ширхэг
10	Малгай /1 удаагийн wc/	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
11	Амны хаалт /1 удаагийн wc/	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
12	Шал угаах сэгсрэгчтэй хувин	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
13	Шал угаах сэгсрэгчний запас алчуур	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 улирлаас дээш хугацаагаар	1 ширхэг
14	Шал угаах урт сойз	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
15	Нарийн цэвэрлэгээний жижиг сойз	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
16	Өндрийн цэвэрлэгээний тоос буулгах сэгсүүрэг	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
17	Хогийн тосгуур, шүүр	Ашиглалтын нөхцөлөөс	1 ширхэг

		хамааран 6-12 сар	
18	Том хувин	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
19	Жижиг хувин	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
20	Мебель өнгөлөгч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 2 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
21	Шил толь өнгөлөгч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
22	Хивс угаагч бодис	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
23	Угаалгын нунтаг	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
24	Барааны саван	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	3 ширхэг
25	Гарын саван	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 2 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
26	Гарын тос	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
27	Агааржуулагч /ариун цэврийн өрөө, хурлын заалны үйлчлэгчид олгоно/	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	2 ширхэг
28	Паркет өнгөлөгч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
29	Плита өнгөлөгч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 2 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
30	Цайруулагч бодис	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
31	Комет	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
32	Ариутгалын бодис	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
33	Хогны уут /ариун цэврийн өрөө/	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 боодол

Гадна талбайн үйлчлэгч

1	Хогны тэргэнцэр	Элэгдэл тооцох хугацаагаар	1 ширхэг
---	-----------------	----------------------------	----------

2	Дэрсэн шүүр	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
3	Хогийн тосгуур, шүүр	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Цас түрэгч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Цас цохигч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Хүрз	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
7	Тармуур	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
8	Гар хадуур	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
9	Гар хайч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
10	Ажлын даавуун бээлий	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 сараас дээш хугацаагаар	1 ширхэг
11	Амны хаалт	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 1 улирлаас дээш хугацаагаар	1 ширхэг

В. ХАВСРАЛТ

Инженер, техникийн ажиллагсдын ажлын багаж хэрэгсэл,
тоног төхөөрөмжийн норм ба хугацаа

№	Ажлын хэрэгслийн нэр	Ашиглалтын хугацаа	Тоо хэмжээ
1	2	3	4
Оператор			
1	Телефон утас	1 жил	1 ширхэг
2	Холбооны утас	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
3	Тестер	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
Лифтчин			
1	Лифтний түлхүүр		
Цахилгаанчин			
1	Цахилгааны гүйдэл хэмжих багаж	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
2	Цахилгаанчны тусгай түлхүүр	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
3	Индикатор	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Овтерканы багц	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Хүйтэн гагнуурын алх	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Метр	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
7	Цохилттой дрилль	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
8	Гагнуурын алх	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
9	Бахь	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
Мужаан			
1	Мужааны тусгай түлхүүр	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
2	Өрөмдөгч багажны багц	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
3	Гар хөрөө	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Овтерканы багц	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Метр	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Алх	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
7	Бахь	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг

8	Тэгш ус	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
9	Дрилль	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
10	Цохилттой дрилль	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
11	Дрилльний нэмэх, хасах хошуу	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
12	Таслагч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
13	Төмрийн хөрөө	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
14	Цахилгаан хөрөө	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
15	Харуул	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг

Слесарь

1	Тасдагч машин	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
2	Тусгай ком	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
3	Слесарийн тусгай түлхүүр	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
4	Гагнуурын аппарат	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
5	Хоолой матагч /газу/	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг
6	Хоолойн резьба татагч	Ашиглалтын нөхцөлөөс хамааран 6-12 сар	1 ширхэг